

БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨЛХИЙН
АУДИТОРЫН ОРЛОГЧ САЛАН БАТБЯМБА

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙХ АУДИТАД
МЭРГЭЖЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр
хот

Дугаар УАГ-АО/2025-09

Улаанбаатар

Ажлын зорилго: “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ, тооцоолол, тайлан, дүгнэлт зөвлөмжийг цаг хугацаанд нь боловсруулан, дүгнэлт өгөхөд чиглэнэ.

Аудит гүйцэтгэх хугацаа:

Шинжээч нь аудитын бүх үе шатны хугацаанд хариуцсан асуудлаар аудитын багт мэргэжил, арга зүйн туслалцааг үзүүлж хамтран ажиллана.

Эхлэх хугацаа: 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр
Дуусах хугацаа: 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр

Байршил: Улаанбаатар хот, Монгол Улс

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд “Аудитын сэдэв батлах тухай” Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний 05 дугаар тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, МУЕА-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу мэргэжлийн тусгай мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг шинжээчээр аудитад татан оролцуулна.

ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Шинжээч нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнгийн гүйцэтгэлд мэргэжлийн түвшинд тооцоо судалгаа, аналитик дүгнэлт гаргах ажлыг хэрэгжүүлнэ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн этгээдийн үйл ажиллагааг хамааруулна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

Д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилж, орон тоог хэвээр хадгалсан эсэх,		Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж, зөвлөмж боловсруулан, дүгнэлт өгөхэд аудитын зорилго чиглэнэ.	✓ Өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилоогүй байх,
2	Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга, засгийн газрын агентлагийн дарга, ТБОНӨ хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга нар суудлын авто машин ашигласан эсэх,	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд "Аудитын сэдэв батлах тухай" Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний 05 дугаар тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, МУЕА-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаал, Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 болон бусад хууль журам, стандарт		✓ Төсвийн байгууллагын дарга нар суудлын авто машин ашиглаагүй байх,
3	Албан томилотоор ажиллахдаа үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож энгийн зэрэглэлээр зорчсон эсэх,			✓ Албан томилотоор ажиллахдаа үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож энгийн зэрэглэлээр зорчсон байх,
4	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан цалин хөлсний нийтлэг жишигийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоосон эсэх, цалин хөлснөөс гадуур ажлын хөлс,			✓ Цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулалт олгоогүй байх,

	урамшуулал олгосон эсэх,		
5	Хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцож буцаан төвлөрүүлсэн үү; төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулсан эсэх;		✓ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцож буцаан төвлөрүүлсэн байх,
6	Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад баталсан эсэх,		Зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын тесел, арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад батлаагүй байх,
7	Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоож, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал дэмжлэг олгосон эсэх,		✓ Орон тоог давхардуулан тогтоосон эсэх, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал дэмжлэг олгоогүй байх,
8	Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь ил тод, нээлттэй цахим хуудсанд байршуулсан эсэх.		Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь ил тод, нээлттэй цахим хуудсанд байршуулсан байх,

ГЭРЭЭТ АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ

- Шинжээчийн үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зайд “single”, үсгийн хэмжээ “arial” 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Шинжээчийн дүгнэлт гаргах үндэслэл болгосон холбогдох нотлох баримт, тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, стандарт норм дүрэм, эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Шинжээч нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах ба тус газрын эрсдэлийн удирдлагын газрын аудитын багт мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллах, ажлын даалгаварт тусгагдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын зорилт үр нөлөөтэй байгаа эсэхийг хянан үзэж, дүгнэлт гаргаж, шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ тооцоолол, санал, тайлбар, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг цаг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж ажлын үр дүнг тусгасан тайлан боловсруулж, гэрээнд заасан хугацаанд ирүүлсэн байна.

Шинжээчийн ажил гүйцэтгэх явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн гүйцэтгэлд илэрсэн алдаа зөрчил, шалтгаан болон үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтээс гадна илэрсэн зөрчлийг арилгах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх талаар зөвлөмж, санал боловсруулж, тайландаа тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэсэн ажлыг нотлох баримтад үндэслэн Мэдээллийн технологийн нэгдсэн төвтэй хамтран журмын дагуу үнэлнэ.

ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээчийн дүгнэлт гаргах иргэн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт тусгасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, дүн шинжилгээ тооцоолол, санал, тайлбар, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг цаг хугацаанд нь үнэн зөв чанартай хийх үндсэн шаардлагыг хангасан байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлэх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Дараах шаардлагыг хангасан иргэнтэй хамтран ажиллана.

Мэдээллийн технологийн чиглэлээр дээд боловсролтой, ажлын даалгаварт заасан мэргэжлийн чиглэлээр нарийн мэргэшсэн, мэдээллийн технологийн аудитын чиглэлээр З ба түүнээс дээш жил ажилласан, судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх, дата анализ хийх, өгөгдлийг цуглуулах, зохион байгуулах, өгөгдлийн сан, статистик, практикийг ашиглаж байсан туршлагатай байх, төрийн болон албаны, байгууллагын нууц хадгалах чадамжтай байх.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан шинжээч нь ажил эхлэхийн өмнө болон аудитын явцад /Аудитын баг/-тай уулзалт, ярилцлага хийж, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Аудитын багт долоо хоног тутамд ажлын явц, гүйцэтгэлийг танилцуулна. Аудитын явцад үүссэн шийдвэрлэх боломжгүй аливаа асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгднээ.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар,
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө, танилцуулга), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугуйлсан байх);
- Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлнэ.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Хянасан:

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ОТГОНБАЯР

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН МЕНЕЖЕР



Н.АНХБАЯР

Боловсруулсан:

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН АУДИТОР



О.НАНДИНЦЭГ